

## Орон нутгийн эдийн засагт арилжааны банкуудын гүйцэтгэх үүрэг

### Role of Commercial Banks in the Local Economy

Э. Жавхлан<sup>1</sup>, Х. Адъяацогт<sup>2</sup>

#### Хураангуй

Арилжааны банк нь санхүүгийн системийн гол субъект болохоос гадна санхүүгийн зах зээл дээрх зуучлагчийн үүргийг гүйцэтгэж, харилцагчдын итгэлцэл дээр тулгуурлаж үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн зах зээлийн нэг чухал институци билээ. Энэхүү судалгааны ажлаар орон нутгийн эдийн засагт арилжааны банкуудын гүйцэтгэх үүргийг тодорхойлохыг зорьсон. Монгол Улсын аймгуудын эдийн засгийн хэмжээ ба чадавхийг илэрхийлэгч үзүүлэлтээр дотоодын нийт бүтээгдэхүүнийг сонгон авч, түүнд арилжааны банктай холбоотой хүчин зүйлс хэрхэн нөлөөлдгийг тодорхойллоо. Эмпирик шинжилгээнд 21 аймгийн 2006-2022 он хүртэлх тоон өгөгдлийг жилийн давтамжтайгаар, үнэлгээг панел өгөгдлийн шинжилгээний аргачлалыг ашиглан хийсэн. Судалгааны үр дүнгээс үзвэл аймгуудын эдийн засагт арилжааны банкуудын гүйцэтгэх үүрэг өндөр байдаг бөгөөд хувийн хэвшлийн санхүүжилтийн гол эх үүсвэр болж, эдийн засгийн өсөлтөд тодорхой үүрэг гүйцэтгэж байна.

*Түлхүүр үгс:* арилжааны банк, аймгууд, дотоодын нийт бүтээгдэхүүн, эдийн засаг, панел загвар

#### Abstract

A commercial bank is not only the main subject of the financial system, but also plays the role of an intermediary in the financial market and is one of the important institutions of the financial market that operates based on the trust of customers. This research aims to determine the role of commercial banks in the local economy. The gross domestic product was selected as an indicator of the economic size and potential of Mongolia's provinces, and how factors related to commercial banks affect it. In the empirical analysis, numerical data from 2006 to 2022 of 21 provinces were analyzed annually, and the evaluation was done using the Panel data analysis method. According to the results of the research, the role of commercial banks in the economy of the provinces is high, and they are the main source of financing for the private sector and play a role in economic growth.

*Keywords:* commercial banks, provinces, gross domestic product, economy, panel model

---

<sup>1</sup> МУИС-ийн Бизнесийн Сургууль, Санхүүгийн тэнхим  
E-mail: e.javkhlan@num.edu.mn

<sup>2</sup> ШУТИС-ын харьяа Эрдэнэт цогцолбор дээд сургууль, Санхүү, менежментийн тэнхим  
E-mail: adiyaatsogt@erdenetis.edu.mn

### Удиртгал

Санхүүгийн салбар, тэр дундаа банкны салбар нийт эдийн засгийн тусгал байдаг. Арилжааны банкуудын үйл ажиллагаа өргөжиж тэдгээрийн хоорондын өрсөлдөөн нэмэгдэн, эдийн засагт гүйцэтгэх үүрэг нь улам илүүтэй өсөн нэмэгдэж байгаа тул тэдний нийгэмд хүлээх хариуцлага их болж байна. Нөгөө талаар арилжааны банкуудын үйл ажиллагаанд урьд таамаглаж байгаагүй эрсдэлүүд гарч, энэ нь эдийн засагт тодорхой сувгаар дамжин нөлөөлдөг. Иймд манай орны санхүүгийн системийн дийлэнх хувийг бүрдүүлэгч банкны салбарын орон нутгийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийг судлах нь чухал юм.

Эдийн засаг өсөх, тэр өсөлтийг иргэддээ хүргэж чадах эсэх нь дотоодын банк санхүүгийн систем хэр найдвартай, эрүүл байгаагаас шууд хамаарна. Монгол Улс зах зээлийн эдийн засгийн системд шилжсэнээр банкны хоёр шатлалт тогтолцоо руу шилжсэн. Энэхүү шилжилтээс хойш өнөөг хүртэлх хугацаанд банкны салбар өөр аль ч салбараас илүүтэй Монголын эдийн засгийг чирч, үндсэн үүргээ сайн гүйцэтгэсээр ирсэн юм. Энэ хугацаанд банкны салбар гурван ч удаа хямралд орж, банкууд дампуурч байсан нь банкны асуудал гэхээсээ илүү тухайн үеийн эдийн засагт тулгарч байсан асуудал гэж үзэж болно. Иймээс эдийн засаг бодитой өсч, тэр өсөлтөө дотооддоо тогтооё, шингээе гэвэл дотоодын санхүүгийн системээ онцгой анхаарч, бусдаас түрүүлэн бэлдэх, дэмжих хэрэгтэй юм.

Банкны салбарын орон нутгийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийг арилжааны банктэй холбоотой хүчин зүйлсээр

тодорхойлж, чухам ямар хүчин зүйл нь илүү нөлөөтэй, хэрхэн нөлөөлдөг болохыг судлах шаардлагын үүднээс энэхүү судалгааны ажлыг хийлээ.

Энэхүү судалгааны ажлын эхэнд судлагдсан байдлын товч тоймыг шинжилгээний аргачлал талаас авч үзсэн. Дараа нь судалгааны ажилд ашиглах арга зүй, эконометрик шинжилгээнд ашиглах загварын тавил, хувьсагчдын тайлбар, үндэслэлийг танилцуулсан. Дараа нь орон нутаг дахь арилжааны банкуудын өнөөгийн байдал, шинжилгээний үр дүнг харуулсан бол төгсгөлд нь дүгнэлтийг танилцуулсан болно.

### Судлагдсан байдал

Арилжааны банкуудын эдийн засагт гүйцэтгэх үүргийг тодорхойлох чиглэлээр хийсэн гадаад судалгааны ажлууд түгээмэл, харин дотоодын энэ чиглэлээр хийсэн эмпирик судалгаа төдийлөн түгээмэл биш байна. Банкны салбарын эдийн засагт гүйцэтгэх үүргийг судлаачид ихэвчлэн банкны санхүүгийн үзүүлэлтүүд нь эдийн засгийн өсөлтөд хэрхэн нөлөөлдөг, хэр үр нөлөөтэй үүрэг гүйцэтгэдэг талаас нь судалжээ. Тухайн судалгааны ажлын үндэслэл, зорилгоос хамаарч эдийн засгийн өсөлт, эсвэл дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) зэрэг үзүүлэлтүүдийг хамааран хувьсагчаар сонгон авч, тэдгээрт банкны өөрийн дотоод хүчин зүйлс хэрхэн нөлөөлдөг болохыг тодорхойлсон судалгааны ажлууд зонхилж байна.

Diallo (2015) 125 орны 1980-2010 оны эдийн засгийн өсөлт, банкны төвлөрлийн тоон өгөгдөл дээр тулгуурлан панел загвараар үнэлгээ хийсэн байна. Банкны салбарын өрсөлдөөнд монополийг шинж

давамгайлсан буюу төвлөрөл өндөр байх тусмаа эдийн засгийн өсөлтөнд сөрөг нөлөө үзүүлдэг гэж дүгнэсэн байна. Мөн банкны технологийн дэвшилд тулгуурлан эдийн засгийн өсөлтийг хангах боломжийг судласан бөгөөд ингэхдээ И.Шумпетерийн өсөлтийн парадигмыг ашигласан байна. Онолын урьдчилсан таамаглалыг батлахын тулд шинжилгээндээ 78 орны 1980-2010 оны тоон мэдээллийг ашигласан ба шинжилгээг панел аргачлал ашигласан хийсэн байна. Энэ хэсгээс банкны технологийн дэвшил нь нэг хүнд ноогдох ДНБ-ийг нэмэгдүүлдэг байна гэсэн дүгнэлтэнд хүрчээ. Эцэст нь санхүүгийн хямралд зээлийн нийлүүлэлтийн шокын үзүүлэх нөлөөлөл, хямралын үед банкны үр ашгаар дамжуулан санхүүгийн салбараас хамааралтай салбаруудын өсөлтийг хангах талаар дурьдсан байна.

Abugamea (2016) 1995-2014 онуудын тоон өгөгдлийг ашиглан хамгийн бага квадратын аргаар шинжилгээ хийжээ. Шинжилгээний үр дүнгээр эдийн засгийн өсөлтөнд банкны зах зээлд эзлэх хувь сөрөг нөлөөтэй, зээл нь статистикийн хувьд ач холбогдолгүй буюу нөлөөгүй, банкны үр ашгийн эдийн засгийн өсөлтөнд үзүүлэх нөлөөлөл сул байна гэж дүгнэжээ.

Abusharbeh (2017) ДНБ-ий өсөлтөнд банкны зээл, хадгаламж, салбарын тоо, хүүний түвшин хэрхэн нөлөөлдгийг тодорхойлсон. Эмпирик шинжилгээнд дурьдсан үзүүлэлтүүдийн 2000-2015 оны хоорондох улирлын мэдээг ашигласан ба энгийн хамгийн бага квадратын аргыг ашиглан регрессийн шинжилгээ хийсэн байна. Шинжилгээний үр дүнгээр Палестиний банкны секторын хөгжил нь эдийн засгийн өсөлтийг дэмжих чухал хүчин зүйл бөгөөд банкны зээл нь эдийн засгийн

өсөлттэй эерэг хамааралтай байдгийг дурьджээ. Түүнчлэн банкны салбарын тоо, хүүний түвшин, хадгаламжийн хэмжээ нь эдийн засгийн өсөлтөнд чухал нөлөө үзүүлдэггүй нь шинжилгээний үр дүнгээс харагдлаа гэсэн байна. Эцэст нь, бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид банкны зээлээр дамжуулан эдийн засгийн өсөлтөнд нөлөөлөх нь үр дүнтэй гэж дүгнэсэн байна.

Al-abadallat (2017) банкны салбарын үр нөлөө нь эдийн засгийн хөгжлийг илэрхийлэх үзүүлэлт ДНБ-д ямар нөлөө үзүүлдгийг тодорхойлсон байна. Судалгааны ажилд тус улсын банкны салбарын 2000-2015 оны ДНБ, зээл, хадгаламжийн статистик мэдээллийг ашигласан ба банкны зээл, хадгаламж нь ДНБ-д нөлөөтэй юу гэсэн таамаглалыг шалгажээ. Статистик таамаглалын үр дүнгээр банкны зээл, хадгаламж нь ДНБ-д нөлөөлөхгүй гэсэн анхдагч таамаглалыг няцааж, өрсөлдөгч таамаглалыг хүлээн зөвшөөрсөн ба өөрөөр хэлбэл Йорданы банкуудын зээл, хадгаламж нь ДНБ-д нөлөөтэй гэсэн таамаглалыг хүлээн зөвшөөрсөн байна. Эндээс үзвэл банкны зээл, хадгаламжаар дамжуулж эдийн засгийн өсөлт буюу хөгжлийг дэмжих боломжтойг харуулжээ.

Naghshpour & Davis (2017) баруун, зүүн, төв Европ гэсэн гурван бүс нутгийн арилжааны банкны хөгжил нь эдийн засгийн өсөлтөд хэрхэн нөлөө үзүүлж буйг эконометрик шинжилгээний аргаар тодорхойлж дүгнэлт хийжээ. Хэдийгээр тус гурван бүс нутаг нь хөгжлийн түвшин, онцлогоороо ялгаатай боловч судалгааны үр дүнгээр банкны хөгжил ба эдийн засгийн өсөлтийн хооронд хүчтэй хамаарал байдгийг харуулсан байна. Тэр дундаа

банкны салбарын хөрөнгө оруулалт нь эдийн засгийн өсөлтөд чухал бөгөөд голлох нөлөө үзүүлдэг гэсэн дүгнэлтийг хийжээ.

Mhadhbi, Terzi, & Bouchrika (2017) нар хөгжиж буй 40 улсын 1970-2012 оны хоорондох банкны салбарын хөгжил ба эдийн засгийн өсөлтийн тоон өгөгдлийг ашиглан тэдгээрийн хоорондын уялдаа, учир шалтгааныг тодорхойлох шинжилгээ хийсэн байна. Эмпирик шинжилгээний үр дүнгээр 25 улсын хувьд эдийн засгийн өсөлт ба банкны салбарын хөгжлийн хооронд ямар нэгэн уялдаатай, харилцан биенээсээ шалтгаалдаг болохыг тодорхойлжээ.

Manish (2020) хожуу аж үйлдвэржсэн, хөгжиж буй орнуудын хөгжилд банкны салбарын гүйцэтгэсэн үүргийг үнэлж баршгүй. Харин хөгжингүй орнуудын хувьд эдийн засгийн салбаруудын хөгжил өндөр түвшинд хүрсэн тул эдийн засгийн өсөлтөд салбаруудын гүйцэтгэх үүрэг ойролцоо байдгийг нотолж, баталсан судалгааны ажил цөөнгүй байна гэжээ.

Anh (2020) Вьетнам улсын арилжааны банкнууд 2007-2018 онд эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд энэ нь ялангуяа арилжааны банкууд дотоодын аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэл болон бизнест богино, урт хугацааны зээл хэлбэрээр хөрөнгө оруулалт хийсэн нь үр дүнгээ өгсөн гэж үзсэн байна.

Арилжааны банкны эдийн засагт гүйцэтгэх үүргийг тодорхойлохдоо дээрх судалгааны ажлуудад дурьдсан аргачлалуудыг түгээмэл ашигладаг байна.

#### Судалгааны арга зүй, өгөгдөл

Эдийн засгийн өсөлт нь банкны дотоод зүйлсээс хэрхэн хамаарч байгааг тогтоохын тулд дараах шугаман регрессийн загварыг үнэлнэ:

$$y_{it} = \alpha_t + \beta_{jt}X_{jt} + \varepsilon_{jt}$$

Үүнд  $j$  - тухайн банкыг илэрхийлэх индекс,  $t$  - тухайн жилийг илэрхийлэх хугацааны индекс,  $y$  - дотоодын нийт бүтээгдэхүүн (GDP),  $X$  - банкны дотоод тайлбарлагч хувьсагчдыг илэрхийлэх үзүүлэлт болно. Дээрх тэгшитгэлийг панел тоон өгөгдлийн Тогтмол нөлөөлөл (Fixed effect) болон Санамсаргүй нөлөөлөл (Random effect)-ийн загварыг ашиглаж хамгийн бага квадратын аргаар үнэлсэн. Тогтмол болон санамсаргүй нөлөөллийн загваруудыг сонгохдоо Хаусмэнийн тестийг ашигласан болно.

Тоо мэдээллийн олдоцоос шалтгаалан шинжилгээнд ашиглах хувьсагчид болон хугацааны интервалыг сонгосон. Хямралыг илэрхийлэх хуурмаг (дамми) хувьсагчийг сонгохдоо аймаг бүрийн ДНБ-ий хугацааны цуваан өгөгдлийг шинжилж үзэхэд ихэнх аймгийн ДНБ 2008-2010 онд буурсан зүй тогтол ажиглагдсан тул эдгээр хугацааны үеүдэд эдийн засгийн гадаад сөрөг шокын нөлөөлөл байсан гэж үзэж 1, хугацааны бусад үеүдэд хямралгүй гэж үзэж 0 гэсэн утга олгосон. Тодруулж хэлбэл 2008 оны сүүл үеэс 2010 оны эхэн үе хүртэл дэлхий нийтийг хамарсан санхүү, эдийн засгийн хямралтай байсан билээ.

Түүнчлэн 2020, 2021 онд дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахал бүх салбарт сөрөг шок хэлбэрээр нөлөөлсөн гэж үзэж Covid гэсэн хуурмаг хувьсагчийг шинжилгээнд ашигласан.

## Хүснэгт 1. Шинжилгээнд ашигласан хувьсагчид

Хувьсагчийн тэмдэглэгээ	Хувьсагчийн нэр	Таамаглаж буй тэмдэг
<i>Хамааран хувьсагч</i>		
<i>GDP</i>	Дотоодын нийт бүтээгдэхүүн, тэрбум төгрөгөөр	
<i>Тайлбарлагч (үл хамааран) хувьсагчид</i>		
<i>S</i>	Салбар нэгжийн тоо	+
<i>Sav</i>	Хадгаламж, тэрбум төгрөгөөр	+
<i>Loan</i>	Зээл, тэрбум төгрөгөөр	+
<i>N</i>	Зээлдэгчийн тоо, мянган хүнээр	+
<i>i</i>	Зээлийн жигнэсэн дундаж хүү	-, +
<i>Emp</i>	Ажиллагсдын тоо	+
<i>Dummy</i>	Хямралын дамми (2008-2010 онуудыг хямралтай гэж үзэв)	-
<i>Covid</i>	Ковид-19 цар тахлын нөлөөг илэрхийлсэн хуурмаг хувьсагч (2020, 2021 онд эдийн засагт цар тахал нөлөөлсөн гэж үзсэн)	-

Бид шинжилгээндээ Монголбанк болон Үндэсний Статистикийн Хорооны статистик мэдээллээс эконометрик загвар болон Хүснэгт 1-д тодорхойлогдсон хувьсагчдын 21 аймгийн 2006-2022 оны, жилээр өгөгдсөн тоон өгөгдлийг цуглуулан ашигласан.

## Шинжилгээний үр дүн

*Орон нутаг дахь арилжааны банкуудын өнөөгийн байдал*

Тоо мэдээний олдоцоос шалтгаалан Хүснэгт 1-д үзүүлсэн арилжааны банкны зарим үзүүлэлтүүдийн өнөөгийн байдлыг энэ хэсэгт авч үзэх болно.


Арилжааны банкны салбар нэгжийг салбар, тооцооны төв, хадгаламжийн касс, төлөөлөгчийн газар, валютын цэг, явуулын касс гэсэн төрлүүдэд ангилдаг ба 2022 оны жилийн эцсийн байдлаар аймаг, орон нутаг дахь арилжааны банкуудын салбар нэгжийн тоо 1,393 байсан бол 2023 оны I улирлын эцсийн байдлаар 1,383 болж буурсан байна. Энэ нь тооцооны төв 4, валют солих цэг 4, бусад нэгж гурваар тус тус буурч Улаанбаатар хот дахь салбар нэгжийн тоо нэгээр нэмэгдсэнээс хамаарчээ.

Зураг 1-ээс харвал арилжааны банкны салбар нэгжийн тоо Сэлэнгэ, Төв аймагт хамгийн олон, Говьсүмбэр аймагт хамгийн цөөн байна. Харин Орхон аймгийн хувьд 32, Булган аймгийн хувьд 38 салбар нэгжтэй байна.


Аймгуудын дунджаар авч үзвэл нэг салбар нэгжид 1,824 хүн; 10,000 хүн тутамд 9 салбар нэгж; газар нутгийн хувьд авч үзвэл 21 аймгийн дунджаар 1,000 км<sup>2</sup> талбайд 1.6 салбар нэгж тус тус ноогдож байна. Манай улсын хувьд 1,000 км<sup>2</sup> талбайд ноогдох банкны салбар нэгжийн тоо Дэлхийн банкны мэдээлснээр 2013 онд 0.94 байсан бол аймгуудын 1,000 км<sup>2</sup> талбайд ноогдох салбар нэгжийн тоо 2013 оны үзүүлэлттэй харьцуулахад 2023 онд 4.4%-иар өссөн байна. 2013 оноос хойш Дорноговь аймгийн банкны салбар нэгжийн тоо 13-аар буурсан бол, Төв 3, Хөвсгөл 2 салбар нэгжээр тус тус нэмэгдсэн байгаа нь бусад аймгуудынхтай харьцуулахад харьцангуй өндөр байна.

Банк дахь харилцах, хадгаламжийн хэмжээг бүсчилж Зураг 2-т харууллаа. Хангайн болон төвийн бүсийн аймгуудын харилцах болон хадгаламжийн хэмжээ бусад бүсүүдтэйгээ харьцуулахад өндөр

Зураг 1. Банкуудын салбар нэгжийн тоо, аймгаар, 2023 оны I улирал



Зураг 2. Банкуудын харилцах, хадгаламжийн хэмжээ, тэрбум төгрөг, бүсээр, 2022 он



Эх сурвалж: Монголбанкны статистик мэдээлэл

байна. Энэ нь тус бүсийн аймгууд эдийн засгийн чадавхи өндөр, уул уурхай, аж үйлдвэрийн салбар илүү хөгжсөнөөс хамаарч байна.

Харилцах дансны үлдэгдэл хамгийн их нь Орхон, Дархан-Уул, Өмнөговь ба харин Говьсүмбэр, Дундговь, Булган аймгуудын харилцах дансны үлдэгдэл хамгийн бага байна. Хадгаламжийн хэмжээ хамгийн их нь Орхон, Дархан-Уул, Өмнөговь, хамгийн бага нь Говьсүмбэр, Булган, Дундговь байгаа нь өмнөх дүгнэлтийг баталж байгаа юм. Харилцахын үлдэгдэл хамгийн бага нь зүүн бүс, хадгаламжийн хэмжээ хамгийн бага нь мөн зүүн бүс байгааг зургаас харж болно.


Аймгуудыг харилцахын хэмжээгээр нь таван интервалд ангилан, ангилал тус

бүрт хамаарах аймгуудыг ижил өнгөөр будаж Зураг 3-д харуулав. Харилцахын хэмжээг аймгуудын дунджаар авч үзвэл 35.1 тэрбум төгрөг байна. Орхон аймгийн хувьд харилцахын хэмжээгээр аймгуудын дунджаас дээгүүр буюу 51.0 тэрбум төгрөгөөс дээш байгаа бол Булган аймгийн хувьд аймгуудын дунджаас доогуур буюу 20.0 тэрбумаас бага хэсэгт багтаж байна.

Ерөнхийдөө уул уурхай, аж үйлдвэр, газар тариалангийн үйлдвэрлэлийн хөгжил сайтай аймгуудын хувьд харилцахын хэмжээ өндөр байгаа бол голчлон мал аж ахуй, газар тариалан дээр төвлөрсөн, хүн амын тоо цөөн, газар нутгийн хэмжээ бага Говьсүмбэр, Булган, Дундговь аймгууд харилцахын хэмжээ хамгийн бага буюу 20.0 тэрбумаас доогуур байна.



Зураг 3. Харилцахын хэмжээ, аймгаар, 2022 он



Зураг 4. Хадгаламжийн хэмжээ, аймгаар, 2022 он




Эх сурвалж: Монголбанкны статистик мэдээлэл

Аймгуудыг хадгаламжийн хэмжээгээр нь мөн таван интервалд ангилан, ангилал тус бүрт хамаарах аймгуудыг ижил өнгөөр будаж Зураг 4-т харуулав. Хадгаламжийн хэмжээг аймгуудын дунджаар авч үзвэл 138.7 тэрбум төгрөг байна. Орхон аймаг нь хадгаламжийн хэмжээгээр дунджаас дээгүүр буюу аймгуудаас хамгийн өндөр байгаа бол Булган аймгийн хувьдунджаас доогуур буюу 90.0 тэрбум төгрөгөөс бага хэсэгт багтаж, доороосоо хоёрдугаарт орж байна.


Нийт зээлийн багцын хэмжээгээр Орхон аймаг 504.8 тэрбум төгрөг, Дархан-Уул

аймаг 407.3 тэрбум төгрөг, Сэлэнгэ аймаг 346.2 тэрбум төгрөгөөр тэргүүлж байгаа бол Говьсүмбэр 76.1 тэрбум төгрөг, Дундговь 136.2 тэрбум төгрөг, Говь-Алтай 155.1 тэрбум төгрөгийн зээлийн багцтайгаар хамгийн бага байна. Зээлийн багц хамгийн их байгаа аймгуудын хувьд уул уурхай, аж үйлдвэржилт, газар тариалангийн салбар бусад аймгуудаас илүү хөгжсөн, эдийн засгийн чадавхи сайтай нь нөлөөлдөг байх талтай юм. Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь хамгийн өндөр нь Дорноговь аймаг 5.9%, хамгийн бага нь Төв аймаг 0.65% байна.

Зураг 5. Зээлдэгчийн тоо, аймгаар, 2022 он



Зураг 6. Нэг зээлдэгчид ноогдох зээлийн хэмжээ, тэрбум төгрөгөөр, 2022 он



Эх сурвалж: Монголбанкны статистик мэдээлэл

Зээлдэгчийн тоогоор (Зураг 5) Хөвсгөл аймаг хамгийн их, Говьсүмбэр аймаг хамгийн бага байна. Хөвсгөл аймгийн хувьд манай улсын аймгуудаас хамгийн олон хүн амтай, аялал жуулчлал хөгжсөн зэрэг хүчин зүйлсээс хамаарч буй юм. Харин Говьсүмбэр аймгийн хувьд хүн амын тоо харьцангуй цөөн, газар нутгийн хэмжээ бага, эдийн засгийн хүчин чадавх сул учир зээлдэгчийн тоо бусад аймгуудтай харьцуулахад цөөн байх магадлалтай юм.

Зураг 6-д нэг зээлдэгчид ноогдох зээлийн хэмжээг харууллаа. Нийт зээлийн багцын хэмжээ, зээлдэгчийн тооноос хамаарч нэг зээлдэгчид ноогдох зээлийн хэмжээ харилцан адилгүй байна. Нэг зээлдэгчид ноогдох зээлийн хэмжээгээр Орхон аймаг тэргүүлдэг бол Булган аймаг хамгийн


бага байна. Ерөнхийдөө аж үйлдвэр, уул уурхай хөгжсөн аймгууд нэг зээлдэгчид ноогдох зээлийн хэмжээгээр тэргүүлдэг нь дээрх зургаас харагдаж байна.

Булган аймгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү хамгийн өндөр байгаа бол (Зураг 7) Өмнөговь аймгийн хамгийн бага, төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү хамгийн өндөр нь Завхан, Архангай аймгийнх 17.7%, хамгийн бага нь Дархан-Уул аймгийнх 18.1% байна.


Аймгууд дахь салбар нэгж болон хүн амын тооноос ажиллагсдын тоо ялгаатай байна., Өмнөговь, Сэлэнгэ, Дорноговь аймгийн банкууд хамгийн олон ажиллагсадтай бол (Зураг 8) Говьсүмбэр, Дундговь, Булган аймаг дахь банкууд бусад аймагтай харьцуулахад хамгийн



Зураг 7. Төгрөгийн зээл болон хадгаламжийн жигнэсэн дундаж хүү, хувиар, 2022 он



Зураг 8. Нэг салбар нэгжид ноогдох ажиллагсдын дундаж тоо, аймгаар, 2022 он



Эх сурвалж: Монголбанкны статистик мэдээлэл

цөөн ажиллагсадтай байна.

Нэг салбар нэгжид ноогдох ажиллагсдын дундаж тоогоор Орхон аймаг хамгийн өндөр, Хэнтий, Увс аймаг хамгийн бага байгаа нь салбар нэгжийн тооноос хамаарч байна.

Тухайн бүсэд хамаарах аймгийн тоо, тухайн аймагт буй банкны салбар нэгжийн тооноос хамаарч ажиллагсдын тоо харилцан адилгүй байна.

#### Эмпирик шинжилгээ

Аймгуудын эдийн засагт банкны дотоод хүчин зүйлс хэрхэн нөлөө үзүүлдэгийг тодорхойлохдоо 21 аймгийн 2006-2022 оны ДНБ болон банкны хүчин зүйлсийн тоон өгөгдөлд үндэслэн үнэлгээг панел тоон өгөгдлийн шинжилгээний Тогтмол

болон Санамсаргүй нөлөөллийн аргаар тооцлоо. Загварын эконометрик үнэлгээг тооцохдоо *Gretl v.2023a* программыг ашигласан болно. Банкны салбар нэгжийн тоо ба ажиллагсдын тоо нь хоорондоо өндөр хамааралтай гарсан тул салбар нэгжийн тоо хувьсагчийг хасаж үнэлсэн. Банкны салбар нэгжийн тооноос ажиллагсдын тооны ДНБ-д үзүүлэх нөлөөг авч үзэх нь бидний судалгааны ажлын зорилгод илүү нийцтэй гэж үзэж уг хувьсагчийг үнэлгээндээ ашиглалаа.

Үнэлгээний үр дүнгээс харвал Тогтмол болон Санамсаргүй нөлөөний загваруудаар ач холбогдолтой гэж үнэлэгдсэн хувьсагчдын тоо ижил байна. Загвар сонголтын хувьд Хаусмены тест ашигласан ба түүний магадлалын утга

## Хүснэгт 2. Үнэлгээний үр дүн

Хувьсагчид	Тогтмол нөлөөний загвар		Санамсаргүй нөлөөний загвар	
	Коэффициент	Магадлал	Коэффициент	Магадлал
<i>const</i>	-177.811 *	0.0695	-165.626 *	0.0940
<i>Sav</i>	2.018 ***	<0.0001	2.077 ***	<0.0001
<i>Loan</i>	1.903 ***	<0.0001	1.900 ***	<0.0001
<i>N</i>	1.838	0.1766	1.675	0.2150
<i>i</i>	7.033 ***	0.0061	6.895 ***	0.0060
<i>Emp</i>	0.047	0.8403	0.014	0.9486
<i>Dummy</i>	34.586 *	0.0846	34.922 *	0.0819
<i>Covid</i>	-58.679 **	0.0421	-63.948 **	0.0268

Hausman test: Chi-square(5) = 11.3423, p-value = 0.0450

\*, \*\*, \*\*\* - харгалзан 10%, 5%, 1%-ийн ач холбогдлын түвшинг илэрхийлнэ.

ойролцоогоор 0.05 гарснаас харвал үнэлгээний GLS арга нь тохиромжтой (Санамсаргүй нөлөөний загвар нь тохиромжтой) гэсэн анхдагч таамаглал няцаагдаж байгаа тул Тогтмол нөлөөний загварыг ашиглан үр дүнгээ тайлбарлалаа.

Панел өгөгдлийн шинжилгээнээс дүгнэж үзвэл:

- Банкуудын хадгаламжийн хэмжээ нэг төгрөгөөр өсөхөд ДНБ 2.02 төгрөгөөр өсдөг бөгөөд өөрөөр хэлбэл банкуудын татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ нэмэгдэх нь зээлээр дамжих аймгуудын эдийн засагт эерэг нөлөө үзүүлж, ДНБ-ий хэмжээг нэмэгдүүлдэг байна.
- Банкуудын зээлийн хэмжээ нэг төгрөгөөр өсөхөд ДНБ 1.90 төгрөгөөр өсдөг бөгөөд өөрөөр хэлбэл зээл олголт нэмэгдэх нь аймгуудын эдийн засагт хөрөнгө оруулалт хэлбэрээр эерэг нөлөө үзүүлж, ДНБ-ий хэмжээг нэмэгдүүлдэг ажээ.
- Зээлийн жигнэсэн дундаж хүү нэг хувиар өсөхөд ДНБ-ий хэмжээ 7.0 тэрбум төгрөгөөр өсдөг бөгөөд энэ нь зээлийн хүү өссөнөөр арилжааны банкны ашигт ажиллагаагаар дамжиж аймгуудын ДНБ-д эерэг нөлөө үзүүлдэг

байх магадлалтай гэж үзэв.

- Эдийн засгийн хямрал нь ДНБ-д эерэг нөлөө үзүүлсэн буюу эдийн засагт хямрал бий болсноор ДНБ-ий хэмжээг 34.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Хямралын үе буюу 2008-2010 онд банкны системийн эдийн засагт нөлөөлдөг гол үзүүлэлт болох зээл болон хадгаламжийн хэмжээ өссөн, түүнчлэн аймгуудын ДНБ-ий хэмжээ 2008-2009 онд буураад, 2009-2010 онд эргээд өссөн байгаа нь хямралыг илэрхийлэх дамми хувьсагчийн утга эерэг гарахад нөлөөлсөн байх талтай. Өөрөөр хэлбэл дэлхий нийтийг хамарсан санхүү, эдийн засгийн хямралын үед арилжааны банкууд өсөлттэй ажиллаж, эдийн засгийн бусад салбартай харьцуулахад хямралд бага өртсөн учир банкны салбарын эдийн засагт үзүүлэх нөлөө нь тус хувьсагчийн коэффициентийг эерэг гарахад нөлөөлсөн гэж үзлээ.
- Ковид-19 цар тахал аймгуудын эдийн засагт сөрөг нөлөө үзүүлсэн буюу хэвийн үетэй харьцуулахад ДНБ-ийг 58.7 тэрбум төгрөгөөр бууруулсан байна. Цар тахалтай холбоотойгоор удаа дараа хөл хорио тогтоосон, хилийн боомтуудыг хаасан нь банкны

системийн эдийн засагт үзүүлэх нөлөөг бууруулж, ДНБ-ий хэмжээнд сөрөг нөлөө үзүүлжээ.

- Үнэлгээний үр дүнгээс харвал аймгуу-дын ДНБ-д бидний сонгож авсан хувьсагчдаас хадгаламжийн хэмжээ, зээлийн хэмжээ, зээлийн жигнэсэн дундаж хүү, эдийн засгийн хямрал, Ковид-19 цар тахал зэрэг хувьсагчид статистикийн хувьд ач холбогдолтой буюу нөлөөтэй гарсан. Бусад хувьсагчдын хувьд нөлөөгүй гэж үнэлэгдсэн.

#### Дүгнэлт

Бид орон нутгийн эдийн засагт арилжааны банкуудын гүйцэтгэх үүргийг тодорхойлон, арилжааны банктай холбоотой хүчин зүйлс нь аймгуудын ДНБ-д хэрхэн нөлөөлдгийг шинжилж, дүгнэлт өгөх зорилго тавин энэхүү судалгааны ажлаа хийлээ. Судалгааны ажлын зорилго дээрээ тулгуурлан дэвшүүлсэн зорилтууд бүрэн биелсэн. Судалгааны ажлынхаа хүрээнд дараах дүгнэлтүүдийг хийж байна.

- Монгол Улс зах зээлийн харилцаанд шилжсэн цагаас хамгийн түрүүнд зах зээлд орсон, түргэн хугацаанд өсч өндийн хөгжсөн салбар бол банкны салбар юм. Өнөөдөр банкны салбарын нийт актив ДНБ-ээс даван гарч хамгийн эрчимтэй хөгжиж буй, олон улсын стандарт, технологийг эрчимтэй нэвтрүүлж байгаа хамгийн том салбар болоод байна.
- Банкны салбар өөр аль ч салбараас илүүтэй өнгөрсөн 33 жил Монголын эдийн засагт шууд болон дам байдлаар эерэг үр нөлөө үзүүлж, үндсэн үүргээ сайн гүйцэтгэсээр ирсэн.

- Орон нутгийн эдийн засагт банкны гүйцэтгэх үүрэг нь голчлон зээл, хадгаламжаар дамжин илэрдэг байна. Ихэнх судалгааны ажлын банкны зээл нь эдийн засаг буюу ДНБ-д нөлөөлдөг гэсэн дүгнэлттэй бидний судалгааны ажлын үр дүн тохирч байна. Хувийн хэвшлийн хувьд зээл нь хөрөнгө оруулалтын гол эх үүсвэр болдог учир байгууллага өргөжин тэлэх, баялаг бүтээхэд зээл нь эерэг нөлөө үзүүлж, ДНБ-ийг өсгөдөг байна.

- Орон нутгийн эдийн засагт банкны салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэхдээ татан төвлөрүүлэх хадгаламжийн хэмжээг нэмэгдүүлэх, зээл олголтыг голчлон бодит секторыг дэмжихэд чиглүүлэх нь орон нутгийн эдийн засаг, тэр дундаа ДНБ-д эерэг нөлөө үзүүлж, өсгөх боломжтой гэдэг нь шинжилгээний үр дүнгээс харагдлаа.

- Судалгааны ажлын хүрээнд авч үзвэл дэлхий нийтийг хамарсан санхүү, эдийн засгийн хямралд орон нутгийн арилжааны банкнууд бусад салбартай харьцуулахад бага өртөж, эдийн засагт эерэг үр дүн авчирч байдаг нь панел өгөгдлийн шинжилгээний үр дүнгээс харагдлаа. Харин гэнэтийн сөрөг шок болох Ковид-19 дэлхий нийтийг хамарсан цар тахал нь орон нутгийн эдийн засагт хилийн боомтууд хаасан, дотоодод удаа дараа хөл хорио, цээрийн дэглэм тогтоосон, арилжааны банкнуудын үйл ажиллагаа, цагийн хуваарийг хязгаарласан зэрэг хүчин зүйлсийн улмаас сөрөг нөлөө үзүүлжээ.

## Ашигласан материал

- Abugamea, G. H. (2016). Banking Sector Development and Economic Growth in Palestine; 1995-2014. *International Journal of Economics and Finance Studies*, 8(2), 117-128.
- Abusharbeh, M. T. (2017). The Impact of Banking Sector Development on Economic Growth: Empirical Analysis from Palestinian Economy. *International Journal of Finance & Economics*, 6(2), 2306-2316.
- Al-abadallat, A. (2017). The Role of the Jordanian Banking Sector in Economic Development. *International Business Research*, 10(4), 139-147.
- Anh, N. T. H. (2020). The Role of Commercial Banks on Economic Growth in Vietnam. *Accounting*, 6, 1001-1006.
- Burzynska, K. (2009). *Financial Development and Economic Growth: The Case of Chinese Banking Sector* [Master Thesis, Lund University].
- Diallo, B. S. (2015). *The Role of the Banking Sector and Financial Markets on Economic Development* [Doctoral Dissertation, University of Quebec in Montreal].
- Drigă, I., & Dura, C. (2014). The Financial Sector and the role of Banks in Economic Development. *Proceedings of the 6th International Multidisciplinary Scientific Symposium Universitaria SIMPRO, Romania*, 598-603.
- Manish, M. K. (2020). The Role of Commercial Banks in Economic Growth in India: A Perspective Study. *International Journal of Education, Modern Management, Applied Science & Social Science*, 2(3), 151-154.
- Mhadhbi, K., Terzi, C., & Bouchrika A. (2019). Banking Sector Development and Economic Growth in Developing Countries: A Bootstrap Panel Granger Causality Analysis. *Empirical Economics*, 58, 2817-2836.
- Naghshpour, S., & Davis, H. L. (2018). The Impact of Commercial Banking Development on Economic Growth: A Principal Component Analysis of Association between Banking Industry and Economic Growth in Eastern Europe. *International Journal of Monetary Economics and Finance*, 11(6), 525-542.
- Банзрагч, М. (2017). Эконометрикийн үндэс. Улаанбаатар.
- Энх-Амгалан, Б. (2017). Эконометриксийн шинжилгээнд Eviews-г ашиглах нь. Улаанбаатар.